



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/НЧ

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 58.2.3, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Оросын холбооны улсын Тува мужаас төслөөр аймагт ирсэн цаа бугануудаас нэг буга ачилтын явцад гэмтэж бэртэж ашиглах боломжгүй болсон тул аймгийн орон нутгийг судлах музейд үзмэр баяжуулахад зориулан ашиглуулсугай.

2. Чихмэл хийхэд гарах зардал 1500,000 /Нэг сая таван зуун мянга/-н төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Г.Төмөрбаатар, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Г.Сувдад зөвшөөрсүгэй.

3. Орон нутгийг судлах музейд Цаа бугын чихмэл хийх ажлын явцад хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга /Ж.Ганболд/-д даалгасугай.

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР